



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 1/66.

Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сорил зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Биеийн тамир, спортын тухай хууль, Засгийн газрын 2005 оны 246, 2009 оны 05 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг биеийн тамирын их, дээд сургуулиудын оюутнуудаас авах ажлыг 2013 оны 12 дугаар сарын 01-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

2. Сорилыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, сорил авах хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 2.500.000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгийг нийслэлийн орон нутгийн төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэг зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний бэлтгэл ажлыг урьдчилан хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны *арваннэгдүгээр* сарын *дөр* өдрийн
1/6 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ СОРИЛ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Дүн /төг/
1.	Багшийн хөлс: /10 хоног х 10 хүн х 20 000 төг	2.000.000
2.	Байгууллагын шагнал	500.000
НИЙТ ДҮН:		2.500.000

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАСАН:

А.БОЛДМАА
О.ЭРДЭНЭЦЭЦЭГ


Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны арваннэгдүгээр сарын 27-ны өдрийн
1/66 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ СОРИЛЫН
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	А.Болдмаа	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Март	МГХ-ны зөвлөх багш, судлаач
	Э.Мөнх-Эрдэнэ	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн
	Л.Алтанцэцэг	ҮБТДС-ийн дэд захирал, доктор (Ph, D), дэд профессор
	Б.Бат-Отгон	МУБИС-ийн Биеийн тамирын дээд сургуулийн багш
	Ц.Энхтуяа	"Мон-Алтиус" Биеийн тамирын дээд сургуулийн багш
	А.Мөнхтогоо	"Мон-Алтиус" Биеийн тамирын дээд сургуулийн оюутан
	А.Болорцэцэг	БГД-ийн 94-р цэцэрлэгийн багш
	Ж.Чулуунцэцэг	ХУД-ийн 34-р сургуулийн багш
Ш.Оюунчимэг	ЧД-ийн 5-р сургуулийн багш	

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны *арвандугаар* сарын *27*-ны өдрийн
А/66 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ СОРИЛ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Байгууллагын нэрс	Хугацаа
1.	ҮБТДС	01/XII - 05/XII
2.	МУБИС	06/XII - 10/XII
3.	"Мон-Алтиус" БТДС	11/XII - 15/XII
4.	"Аварга" БТДС	16/XII - 20/XII
5.	"Шонхор" БТДС	21/XII - 25/XII